БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БУА-2021/80/СТА-ТШЗ


Цахим хуудас: www.audit.mn
Булган аймаг
2020 он

Аудитын хоёрдугаар газрын захирал,
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг:
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг:
Ахлах аудитор: Г.Намчинсүрэн
Утас: 70342716 Цахим хаяг:


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

**Агуулга**

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....13
3. Аудитын тайлан....14
3.1. Ерөнхий зүйл....14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ....15
3.4. Материаллаг байдал ....15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....17
3.7. Шилэн дансны мэдээлэл ....17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....18
3.9. Аудитын илрүүлэлт....18
Залруулсан алдаа....18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ....18
Аудитын зөвлөмж....19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд....19
4. Менежментийн захидал....20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....23

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **44,295,195.82** | **48,137,450.22** |
| **33** | **АВЛАГА** | 4,776,588.38 | 907,228.38 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 50,000.00 | 84,030.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 4,033,620.00 | 130,230.00 |
| **335** | **Бусад авлага** | 692,968.38 | 692,968.38 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 692,968.38 | 692,968.38 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 39,518,607.44 | 47,230,221.84 |
| **351** | **Түүхий эд материал** | 10,072,394.90 | 15,413,285.80 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 5,985,107.80 | 5,985,107.80 |
| 35130 | Эм боох материал | 4,087,287.10 | 9,428,178.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 29,446,212.54 | 31,816,936.04 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 611,900.00 | 662,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 25,228,454.34 | 26,568,360.34 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,663,100.00 | 1,663,100.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 126,600.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,942,758.20 | 2,796,775.70 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **301,166,423.75** | **419,293,724.47** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 301,166,423.75 | 419,293,724.47 |
| **392** | **Биет хөрөнгө** | 286,115,623.75 | 404,242,924.47 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 258,871,928.76 | 258,120,338.76 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (20,031,230.45) | (38,920,601.09) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 88,430,143.00 | 219,662,468.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (56,396,861.67) | (69,383,035.15) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 86,690,739.44 | 56,663,857.86 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (74,883,217.95) | (25,342,426.87) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 8,307,599.91 | 7,937,400.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (4,873,477.29) | (4,495,077.04) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 15,050,800.00 | 15,050,800.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 15,050,800.00 | 15,050,800.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **345,461,619.57** | **467,431,174.69** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2,168,522.00** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 2,168,522.00 | - |
| **413** | **Өглөг** | 2,168,522.00 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 36,322.00 | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 2,132,200.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **343,293,097.57** | **467,431,174.69** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 343,293,097.57 | 467,431,174.69 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 244,527,471.75 | 244,527,471.75 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (55,063,475.53) | 69,826,191.59 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (55,063,475.53) | (54,311,885.53) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 124,138,077.12 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 153,829,101.35 | 153,077,511.35 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **345,461,619.57** | **467,431,174.69** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **475,975,765.58** | **683,369,561.18** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **54,840,365.58** | **198,514,451.18** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 46,871,145.58 | 198,514,451.18 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 46,871,145.58 | 198,514,451.18 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 46,871,145.58 | 198,514,451.18 |
| **122** | **Тусламжийн орлого** | 7,969,220.00 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 7,969,220.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **421,135,400.00** | **484,855,110.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 378,841,600.00 | 398,559,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 378,841,600.00 | 398,559,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 400,800.00 | 21,733,100.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 400,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 100,000.00 | 21,262,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 300,800.00 | 70,600.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 41,893,000.00 | 43,591,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 41,893,000.00 | 43,591,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | - | 20,971,810.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | - | 20,971,810.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **476,349,864.34** | **533,096,099.28** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **476,349,864.34** | **533,096,099.28** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 474,734,736.34 | 531,991,359.01 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 273,282,922.00 | 321,504,131.68 |
| 210101 | Үндсэн цалин | 210,811,322.00 | 213,665,714.74 |
| 210102 | Нэмэгдэл | 43,372,800.00 | 86,771,491.94 |
| 210104 | Урамшуулал | 19,098,800.00 | 21,066,925.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34,155,800.00 | 42,719,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,225,900.00 | 30,340,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,732,500.00 | 2,885,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,186,000.00 | 2,334,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 546,500.00 | 829,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,464,900.00 | 6,328,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 40,065,046.00 | 41,222,541.05 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,270,928.00 | 2,359,611.00 |
| 210302 | Түлш, халаалт | 34,289,770.00 | 36,361,786.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,504,348.00 | 2,501,144.05 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,797,640.00 | 24,170,019.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,484,900.00 | 1,504,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,337,090.00 | 17,268,720.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,486,800.00 | 1,463,555.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,019,500.00 | 2,440,894.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,469,350.00 | 1,492,250.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 49,822,146.13 | 50,078,765.78 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 42,635,772.48 | 46,276,137.28 |
| 210502 | Хоол, хүнс | 6,173,373.65 | 3,685,028.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,013,000.00 | 117,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,476,100.00 | 3,484,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,404,100.00 | 462,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,072,000.00 | 3,022,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,446,000.00 | 1,354,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,446,000.00 | 1,354,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 680,540.00 | 587,950.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 75,200.00 | 155,950.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 496,000.00 | 432,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 65,340.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 46,008,542.21 | 46,870,151.50 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,689,699.00 | 3,417,592.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 36,318,843.21 | 43,452,559.50 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,615,128.00 | 1,104,740.27 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 1,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,000,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 46,788.95 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 46,788.95 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (26,135,384.78) |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **425,882,850.00** | **488,888,730.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,935,600.00** | **-** |
| **122** | **Тусламжийн орлого** | 3,935,600.00 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 3,935,600.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **421,947,250.00** | **488,888,730.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 378,841,600.00 | 398,559,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 378,841,600.00 | 398,559,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,212,650.00 | 21,733,100.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 400,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 911,850.00 | 21,262,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 300,800.00 | 70,600.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 41,893,000.00 | 43,591,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 41,893,000.00 | 43,591,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | - | 25,005,430.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | - | 25,005,430.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **424,341,625.00** | **486,490,730.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **424,341,625.00** | **486,490,730.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **422,726,497.00** | **485,055,759.73** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 273,138,275.00 | 321,574,483.68 |
| 210101 | Үндсэн цалин | 210,775,000.00 | 216,147,251.74 |
| 210102 | Нэмэгдэл | 43,264,475.00 | 84,326,276.94 |
| 210104 | Урамшуулал | 19,098,800.00 | 21,100,955.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34,155,800.00 | 42,719,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,225,900.00 | 30,061,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,732,500.00 | 3,164,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,186,000.00 | 2,531,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 546,500.00 | 632,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,464,900.00 | 6,328,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 38,820,046.00 | 41,222,541.05 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,270,928.00 | 2,359,611.00 |
| 210302 | Түлш, халаалт | 33,044,770.00 | 36,361,786.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,504,348.00 | 2,501,144.05 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,894,340.00 | 24,462,625.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 1,470,600.00 | 1,469,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,337,090.00 | 17,395,320.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,486,800.00 | 1,486,355.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,130,500.00 | 2,621,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,469,350.00 | 1,489,250.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 35,972,497.00 | 45,079,168.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 30,759,037.00 | 37,021,542.00 |
| 210502 | Хоол, хүнс | 4,200,460.00 | 6,940,026.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,013,000.00 | 1,117,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,636,100.00 | 3,297,670.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,564,100.00 | 976,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,072,000.00 | 2,321,670.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,900,000.00 | 1,900,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,900,000.00 | 1,900,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 680,540.00 | 602,950.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 75,200.00 | 170,950.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 496,000.00 | 432,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 65,340.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,528,899.00 | 4,196,822.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,528,899.00 | 4,196,822.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,615,128.00** | **1,434,970.27** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 1,200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,200,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,615,128.00 | 57,951.32 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,615,128.00 | 57,951.32 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 46,788.95 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 46,788.95 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 108,325.00 | 130,230.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 108,325.00 | 130,230.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,541,225.00** | **2,398,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,432,900.00** | **2,398,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,432,900.00** | **2,398,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,432,900.00 | 2,398,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 1,432,900.00 | 2,398,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(1,432,900.00)** | **(2,398,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Бусад** | **Засгийн газрын хувь оролцооний нийт дүн** |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 244,527,471.75 | 153,829,101.35 | (55,063,475.53) | | 343,293,097.57 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **244,527,471.75** | **153,829,101.35** | **(55,063,475.53)** | **-** | 343,293,097.57 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **244,527,471.75** | **153,829,101.35** | **(55,063,475.53)** | **-** | 343,293,097.57 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 751,590.00 | | 751,590.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **244,527,471.75** | **153,829,101.35** | **(54,311,885.53)** | **-** | 344,044,687.57 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (751,590.00) | - | | (751,590.00) |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 124,138,077.12 | | 124,138,077.12 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **244,527,471.75** | **153,077,511.35** | **69,826,191.59** | **-** | 467,431,174.69 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 423055072.00 | 465553200.00 | 461764369.73 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 423055072.00 | 465553200.00 | 461764369.73 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 423055072.00 | 464553200.00 | 460764369.73 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 273246600.00 | 316440500.00 | 316439300.68 |
| Үндсэн цалин | 210,775,000.00 | 211012100.00 | 211012068.74 |
| Нэмэгдэл | 43,372,800.00 | 84327200.00 | 84326276.94 |
| Урамшуулал | 19,098,800.00 | 21101200.00 | 21100955.00 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34155800.00 | 42719500.00 | 42719500.00 |
| Тэтгэврийн даатгал | 23225900.00 | 30061900.00 | 30061900.00 |
| Тэтгэмжийн даатгал | 2732500.00 | 3164400.00 | 3164400.00 |
| ҮОМШӨ-ний даатгал | 2186000.00 | 2531500.00 | 2531500.00 |
| Ажилгүйдлийн даатгал | 546500.00 | 632900.00 | 632900.00 |
| Эрүүл мэндийн даатгал | 5464900.00 | 6328800.00 | 6328800.00 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 38820046.00 | 41269000.00 | 41222541.05 |
| Гэрэл, цахилгаан | 2270928.00 | 2366000.00 | 2359611.00 |
| Түлш, халаалт | 33044770.00 | 36398000.00 | 36361786.00 |
| Цэвэр, бохир ус | 3504348.00 | 2505000.00 | 2501144.05 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 22585140.00 | 25086700.00 | 24462625.00 |
| Бичиг хэрэг | 1,470,600.00 | 1470600.00 | 1469800.00 |
| Тээвэр, шатахуун | 15,577,890.00 | 18006800.00 | 17395320.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,486,800.00 | 1,486,800.00 | 1,486,355.00 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,580,500.00 | 2,622,500.00 | 2,621,900.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,469,350.00 | 1,500,000.00 | 1,489,250.00 |
| **Нормативт зардал** | 35,972,497.00 | 27,088,500.00 | 24,394,653.00 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 30,759,037.00 | 18,030,900.00 | 16,337,027.00 |
| Хоол, хүнс | 4,200,460.00 | 7,940,000.00 | 6,940,026.00 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,013,000.00 | 1,117,600.00 | 1,117,600.00 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,054,000.00 | 5,322,000.00 | 5,321,670.00 |
| Багаж, техник, хэрэгсэл | 2,982,000.00 | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| Урсгал засвар | 3,072,000.00 | 2,322,000.00 | 2,321,670.00 |
| **Томилолт, зочны зардал** | 1,900,000.00 | 1,900,000.00 | 1,900,000.00 |
| Дотоод албан томилолт | 1,900,000.00 | 1,900,000.00 | 1,900,000.00 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 680,540.00 | 1,024,000.00 | 602,950.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 75,200.00 | 189,000.00 | 170,950.00 |

| | | | |
|---|---|---|---|
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 496,000.00 | 432,000.00 | 432,000.00 |
| Даатгалын үйлчилгээ | - | 116,000.00 | - |
| Тээврийн хэрэгслийн татвар | 65,340.00 | - | - |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 70,000.00 | - |
| Газрын төлбөр | - | 217,000.00 | - |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,640,449.00 | 3,703,000.00 | 3,701,130.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 9,640,449.00 | 3,703,000.00 | 3,701,130.00 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | - | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 423,055,072.00 | 465,150,200.00 | 461,764,369.73 |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 377,227,426.00 | 398,559,200.00 | 398,501,248.68 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 377,227,426.00 | 398,559,200.00 | 398,501,248.68 |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 41,892,046.00 | 43,591,000.00 | 43,544,211.05 |
| Орон нутгийн төсвөөс | 41,892,046.00 | 43,591,000.00 | 43,544,211.05 |
| **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,935,600.00 | 23,000,000.00 | 19,718,910.00 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 3,935,600.00 | 23,000,000.00 | 19,718,910.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,212,200.00 | 21,733,100.00 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,212,200.00 | 21,733,100.00 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,212,200.00 | 21,733,100.00 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | - | 5,135,183.00 |
| Үндсэн цалин | - | 5,135,183.00 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 759,200.00 | - |
| Бичиг хэрэг | - | - |
| Тээвэр, шатахуун | 759,200.00 | - |
| **Нормативт зардал** | - | 15,397,995.00 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 15,397,995.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 453,450.00 | 869,692.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 453,450.00 | 869,692.00 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 200,000.00 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | - | 200,000.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 200,000.00 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,212,200.00 | 21,652,700.00 |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,212,200.00 | 21,652,700.00 |
| Төрийн болон орон нутгийн татаас санхүүжилт | - | 130,230.00 |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 300,800.00 | |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 911,850.00 | 21,262,500.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 470,600.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Тэшиг сумын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч их эмч Ц.Алтантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Тэшиг сумын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахьТөрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22 ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тэшиг сумын Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн эрүүл мэнд
- Хэвтүүлэн эмчлэх
- Оношилгоо
- Дэмжих үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайд эрүүл мэндийн сайдын 2019 оны 611 дугаар тушаал
- Коронавируст халдварын үеийн түр заавар
- Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед эрүүл мэндийн байгууллагын ажиллах нийтлэг журам
- Коронавируст халдварын үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зарим хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуур хуваарилах тухай
- Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг батлах тухай А/37 тоот тушаал
- Хөрөнгө бүртгэх тухай /Шинэ коронавирус халдварын үед иргэд, аж ахуй нэгж, албан байгууллагуудаас эрүүл мэндийн яаманд хандивласан тоног төхөөрөмж, бараа материал/
- Хөрөнгө хуваарилах тухай /Шинэ коронавирус халдварын үед иргэд, аж ахуй нэгж, албан байгууллагуудаас эрүүл мэндийн яаманд хандивласан тоног төхөөрөмж, бараа материал хуваарилалт/

- Эмнэлгийн хэрэгсэл хувийн хамгаалах хэрэгсэл хуваарилах тухай

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой бүрэн нийцсэн байна.

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит болон харьяалах дээд байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн тайлангийн нийт зардлын 255728.0 мянган төгрөгөөс *2* хувиар буюу 5114.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагатай гэж үзлээ.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын 559231.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 11184.6 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тооцлоо.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Тэшиг сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 118127.3 мянган төгрөгөөр буюу 35.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/төгрөг/

| *Данс ны код* | *Дансны нэр* | *Тайлант оны эхний үлдэгдэл* | *Тайлант оны эцсийн үлдэгдэл* | *Зөрүү* | |
|---|---|---|---|---|---|
| | | | | *Дүн* | *Хувь* |
| *А* | *2* | *3* | *4* | *5* | *6* |
| *1* | *ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН* | *44,295,195.82* | *48,137,449.86* | *3,842,254.04* | *8.7* |
| *33* | *АВЛАГА* | *4,776,588.38* | *907,228.38* | *-3,869,360.00* | *-81.0* |
| *35* | *БАРАА МАТЕРИАЛ* | *39,518,607.44* | *47,230,221.48* | *7,711,614.04* | *19.5* |
| *2* | *ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН* | *301,166,423.75* | *419,293,724.47* | *118,127,300.72* | *39.2* |
| *39* | *ҮНДСЭН ХӨРӨНГӨ* | *301,166,423.75* | *419,293,725.47* | *118,127,301.72* | *39.2* |
| *3* | *НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН* | *345,461,619.57* | *467,431,175.33* | *121,969,555.76* | *35.3* |
| *4* | *НИЙТ ӨР ТӨЛБӨР* | *2,168,522.00* | | *-2,168,522.00* | *-100.0* |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| *41* | *БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР* | *2,168,522.00* | | *-2,168,522.00* | *-100.0* |
| *5* | *ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН* | *343,293,097.57* | *467,431,174.69* | *124,138,077.12* | *36.2* |
| *6* | *ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V* | *345,461,619.57* | *467,431,175.69* | *121,969,556.12* | *35.3* |

Авлага дансны үлдэгдэл 907.2 мянган төгрөг болж 3869.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлага 4033.0 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлага барагдаж тайлант онд шинээр ажилчидтай холбоотой 34.0, татаас санхүүжилтийн авлага 130.2 мянган төгрөгийн авлага үүссэн нь шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн байгууллагаас авах орон нутгийн авлага, он удаан жил болсон 692.9 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 47230.2 мянган төгрөг болж 7711.6 мянган төгрөгөөр өссөн нь ЭМГ -аас шилжүүлсэн үнэ төлбөргүй оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл 5340.8, хүнсний материал 854.0, бичиг хэргийн 50.2, сэлбэг хэрэгсэл 126.6 мянган төгрөгийн нөөцийг тус тус бүрдүүлснээс шалтгаалжээ.

Энэ нь санхүүгийн тайлангийн эцсийн хэрэглэгчдэд хүргэх санхүүгийн мэдээлэл үнэн зөв илэрхийлэгдэхгүй эрсдэлтэй байна. Оны эцэст 1580.8 мянган төгрөгийн худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй, үр дүнгүй зарцуулах эрсдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 419213.0 мянган төгрөг болж 127121.3 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгийн дахин үнэлгээ, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж нэмэгдсэн нь шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 0.00 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 2398.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээр 185317.2 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс өртгөө нөхсөн 38705.8, акталсан 87631.6, үнэ төлбөргүй шилжүүлсэн 29700.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгөнд тайлант онд өөрчлөлт гараагүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0.00 мянган төгрөг болж 43.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн өглөгийг барагдуулсан нь шалтгаалжээ.

Тэшиг сумын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 153367.4 мянган төгрөгөөр буюу 43.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө хүлээн авсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 56746.2 мянган төгрөгөөр буюу 11.9 хувиар өссөн буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт цалингийн зардал байна. Энэ нь 2020 оны нэгдүгээр сарын 01-нээс Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор 8 хувь нэмэгдсэн байна.

### 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 500190.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 500190.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс мянган төгрөгөөр 35039.8 бууруулж 465150.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр 465150.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 398559.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 43591.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 23000.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн төсөв, дээд шатны төсвийн захирагчаас НДС-аас төсвөөс нийт 461764.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 461764.3 мянган төгрөгийг зарцуулж 104.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 461764.3 мянган төгрөг буюу 99.27 хувьтай байгаа нь НДС-ийн санхүүжилт 3281.0 мянган төгрөгөөр дутуу орж ирсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулаагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 21262.5 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 70.6 мянга, хандив тусламж 400.0, нийт 21733.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалинд 5135.2 мянга, эм боох хэрэгсэлд 15397.9, бараа үйлчилгээний бусад зардалд 869.6, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 200.0 нийт 21602.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 130.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 177 мэдээллээс хугацаандаа оруулсан 173 хугацаа хоцроосон 3 мэдээлэл, огт мэдээлээгүй буюу дараа жилийн батлагдсан төсөв 465.1 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 8243.7 мянган төгрөгийн зөрчилд 110.5 мянган төгрөгийн төлбөрийн акт, 30.0 мянган төгрөгийн албан шаардлага, 8103.2 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлснийг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 8103.2 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 110.5 | 1 | 110.5 | | | |
| Албан шаардлага | 1 | 30.0 | 1 | 30.0 | | | |
| Зөвлөмж | 1 | 8103.2 | 1 | 8103.2 | | | |
| Нийт дүн | 3 | 8243.7 | 3 | 8243.7 | | | |

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 302980.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 366.2 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 277927.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 24686.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулга хийгдээгүй болно.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 302980.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 366.2 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож 277927.6 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Цалингийн зардлаас ХХОАТ, НДШ-ийн өглөг дансанд давхар бичилт хийгээгүй шууд зардалд 62622.4 мянган төгрөгийн дансны бичилтийн алдаа илэрсэн нь санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.
<u>Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага.</u>

2. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" , 42.2.2 дахь "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтуудыг зөрчин ЭМГ-ын дарга, засаг даргаар батлуулаагүй орон тооны ажлыг бага эмч, сувилагчид хавсран гүйцэтгүүлж батлагдсан төсөвт тусгагдаагүй ажил хавсран гүйцэтгэсэн нэмэгдэл 1328.6 мянган төгрөгийн цалинг олгосон нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, хэмжилт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
<u>Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага</u>

3. Санхүүгийн тайлангийн тодруулга дахь нийт эмийн орлого,зарлага, нярвын эмийн орлого, зарлагын нийт дүнгээс 4527.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь санхүүгийн

тайлангийн аудитын иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага

4. Жилийн эцсийн тооллогоорх бараа материалын үлдэгдэл санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн дүнгээс 7949.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага

5. Жилийн эцэст 201499.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллогыг хийгээгүй нь ТБОӨТХ-ийн 72, 73.2, НББ-ийн тухай хуулийн 20.2.6, санхүүгийн тайлангийн аудитын оршин байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага

6. Жилийн эцсийн бараа материалын тооллогоор 279.2 мянган төгрөгийн хүнс дутсан нь ТБОНӨТХ-ийн 73.1, 73.4, НББ-ийн тухай хуулийн 12.4 дэх заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын оршин байх, иж бүрэн байх, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

7. Тээвэр шатахууны үлдэгдэл санхүүгийн тодруулга тайлангаас 21.7 мянган төгрөгөөр дутсан нь ТБОӨТХ-ийн 73.1, 73.4, НББ-ийн тухай хуулийн 12.4 дэх заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын оршин байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

8. Бараа материалын тодруулга дахь эмийн зарцуулалтын тайлан эмийн захиалга, өдрийн түүврийн дүнгээс 65.3 мянган төгрөгөөр зөрүүтэй нь НББ-ийн тухай хуулийн 13.7 дахь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 2686.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Байхгүй

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

***1. Зардлын данстай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

- Цалингийн зардлаас нэг удаагийн шагнал урамшууллын зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй шилжүүлэн зарцуулсан нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.5 дахь заалт, сангийн сайдын 2015-1-20-ны өдрийн 7-р тушаал, санхүүгийн тайлангийн үнэн байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*1.2. <u>Эрсдэл:</u>*

- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх
- Холбогдох дүрэм, журам зөрчигдөх

*1.3. <u>Өгсөн зөвлөмж</u>*

- Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.5 дахь заалт, сангийн сайдын 2015-1-20-ны өдрийн 7-р тушаал бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

*1.4. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>*

- Хүлээн зөвшөөрч байна. Цаашид төсөв зардлыг зүйл анги бүрээр зөв зарцуулж, алдаа гаргахгүй ажиллана.

***2. Зардлын данстай холбоотой асуудал***

*2.1. <u>Илрүүлэлт:</u>*

- Тендерт шалгараагүй аж ахуй нэгж байгууллагаас 8264.1 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгслийн худалдан авалт хийсэн нь санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*2.2. <u>Эрсдэл:</u>*

- Холбогдох хуулийн заалт зөрчигдөх
- Баталгаагүй эм, эмнэлгийн хэрэгсэл бэлтгэх

*2.3. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

- Холбогдох хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллах

*2.4. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>*

- Тендерт шалгарсан компаниас эмийн татан авалт хийхээр шаардлагатай эм, эмийн хэрэгсэл оношлуур байхгүй хүндрэлтэй асуудал үүсдэг. Иймээс тендертэй байгууллагуудад эмийн жагсаалтаа явуулж, ханган ажиллах талаар санал хүргүүлсэн. Цаашид тендертэй байгууллагаас татан авалт хийх талаар арга хэмжээ авч ажиллана. COVID-19 цар тахалтай холбогдуулан нөөцөд 4283250 төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл бэлдсэн Тендерийн багцад ороогүй байсан.

***3. Зардлын данстай холбоотой асуудал***

*3.1. <u>Илрүүлэлт:</u>*

- Эм ханган нийлүүлдэг харилцагч байгууллагуудаас 2 аж ахуй нэгжтэй тооцоо нийлж бусад харилцсан байгууллагатай 9344.4 мянган төгрөгийн тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, өмнөх оны авлагын үлдэгдэл 1631.8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй зэрэг нь НББ-ийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. *<u>Эрсдэл</u>*:

- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх
- Залилан үүсэх нөхцөлийг бүрдүүлэх

3.3. *<u>Өгсөн зөвлөмж:</u>*

- НББ-ийн тухай хуулийн 14.4.3, 20.2.6 дахь заасны дагуу харилцагч байгууллагатай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж ажиллах.

3.4. *<u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>*

- Эм ханган нийлүүлдэг компанийн хувьд Монос Булган, Булган Эм хангамжтай тооцоо нийлж бусад газартай дахин худалдан авалт хийгээгүй учир тооцоо нийлээгүй. Цаашид зөрчлөө арилган, сар бүр хяналт тавьж, хагас бүтэн жилээр тооцоо нийлэн ажиллана.

### 4. Зардлын данстай холбоотой асуудал

4.1. *<u>Илрүүлэлт:</u>*

- Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын 5088.9 мянган төгрөгийн баримтыг аваагүй /цахим Е баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй". заалтуудыг зөрчиж НӨАТ-ын баримтгүй нийт 7525.0 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэл бэлдсэн нь санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. *<u>Эрсдэл</u>*:

- Холбогдох хуулийн заалт зөрчигдөх

4.3. *<u>Өгсөн зөвлөмж:</u>*

- Худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримттай бараа, үйлчилгээг авч байх, цаг тухайд цахим Е баримтыг хангуулан бүртгэлд тусгах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулна.

4.4. *<u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>*

- Эгийн далай ХХК эмийн сан нь Е баримт бүрэн шивсэн байна, Булган эм хангамж эцсийн хэрэглэгчээр е баримт шивсэн.

### 5. Үндсэн чиглэл

**5.1.** *<u>Илрүүлэлт:</u>*

- Шилэн дансанд Төсөвт байгууллагын 2 дугаар сарын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн мэдээг хугацаа хоцроон мэдээлсэн, дараа жилийн төсвийн төслийг мэдээлээгүй байна.

*5.2.* *<u>Эрсдэл:</u>*

- Холбогдох хуулийн заалт зөрчих

*5.3.* *<u>Өгсөн зөвлөмж:</u>*

- Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд тухай бүр мэдээлж байх

*5.4.* *<u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>*

- Хүлээн зөвшөөрч байна. Цаашид хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР Г.НАМЧИНСҮРЭН

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| **2021** Огноо: | Аудитын нэр: | ***Тэшиг сумын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | БУАГ-2021/80/СТА-ТШ3 |
| Шалгагдсан байгууллагын нэр: | **Тэшиг сум Эрүүл мэндийн төв** | | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Цалингийн зардлаас нэг удаагийн шагнал урамшууллын зардлыг зарцуулсан. | 357.3 | Зөвлөмж | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ц.Алтантуяа, Б.Оюунбямба |
| 2 | Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" тухай заалтыг зөрчсөн | 1328.6 | Албан шаардлага | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ц.Алтантуяа, Б.Оюунбямба |
| 3 | Цалингийн зардлаас ХХОАТ, НДШ-ийн өглөг дансанд давхар бичилт хийгээгүй шууд зардалд бичсэн | 62622.4 | Албан шаардлага | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ц.Алтантуяа, Б.Оюунбямба |
| 4 | Эм ханган нийлүүлдэг харилцагч байгууллагуудаас 2 аж ахуй нэгжтэй тооцоо нийлж бусад харилцсан байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, өмнөх оны авлагын үлдэгдэл 1631.8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй | 10976.2 | Зөвлөмж | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ц.Алтантуяа, Б.Оюунбямба |
| 5 | Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй | 5088.9 | Зөвлөмж | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ц.Алтантуяа, Б.Оюунбямба |
| 6 | Жилийн эцсийн бараа материалын тооллогоор 279.2 мянган төгрөгийн хүнс дутсан. | 279.2 | Төлбөрийн акт | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ц.Алтантуяа, Б.Оюунбямба |
| 7 | Тээвэр шатахууны үлдэгдэл санхүүгийн тодруулга тайлангаас 21.7 мянган төгрөгөөр дутсан. | 21.7 | Төлбөрийн акт | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ц.Алтантуяа, Б.Оюунбямба |
| 8 | Тендерт шалгараагүй аж ахуй нэгж байгууллагаас эм, эмийн хэрэгслийн худалдан авалт хийсэн | 8264.1 | Зөвлөмж | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ц.Алтантуяа, Б.Оюунбямба |
| 9 | Жилийн эцсийн тооллогоорх бараа материалын үлдэгдэл санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн дүнгээс 7949.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан | 7949.3 | Албан шаардлага | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ц.Алтантуяа, Б.Оюунбямба |
| 10 | Санхүүгийн тайлангийн тодруулга дахь нийт эмийн орлого,зарлага, нярвын эмийн орлого, зарлагын нийт дүнгээс 4527.9 мянган төгрөгөөр зөрүүтэй | 4527.9 | Албан шаардлага | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ц.Алтантуяа, Б.Оюунбямба |
| 11 | Бараа материалын тодруулга дахь эмийн зарцуулалтын тайлан эмийн захиалга, өдрийн түүврийн дүнгээс зөрүүтэй. | 65.3 | Төлбөрийн акт | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ц.Алтантуяа, Б.Оюунбямба |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | Шилэн дансанд Төсөвт байгууллагын 2 дугаар сарын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн мэдээг хугацаа хоцроон мэдээлсэн, дараа жилийн төсвийн төслийг мэдээлээгүй байна. | 0.00 | Зөвлөмж | Эрхлэгч, Нягтлан бодогч | Ц.Алтантуяа, Б.Оюунбямба |
| **ДҮН** | | **302980.3** | | | |